**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН**
**ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 09 сарын 19 өдөр　　　　Дугаар 98　　　　Номгон

Орон нутгийн өмчид хөрөнгө
бүртгэж, эзэмшигч тогтоох тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "а","в", Улсын Их Хурлын 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 61 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжин ирсэн 4 нэрийн 322,956,3 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэсүгэй.

2. Орон нутгийн өмчид бүртгэсэн хөрөнгийн эзэмшигчийг хавсралтаар баталж холбогдох байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсүгэй.

3. Дээрх хөрөнгүүд болон Төрийн банкны хуучин барилгыг газрын хамт хүлээн авах, хүлээлгэн өгөх ажлыг комисс байгуулан тухайн байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

4. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

4.1. Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

4.2 Энэхүү тогтоолын хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэх.

4.3.Улсын Их Хурлын 61 дүгээр тогтоолын хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сард багтаан гаргаж Төрийн өмчийн Бодлого зохицуулалтын газарт хүргүүлэх.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА　　　　Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/TH togtool-2018

0118103

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын
19-ний өдрийн 98 дугаар тогтоолын хавсралт

## ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД ШИЛЖИН ИРСЭН ХӨРӨНГӨД ЭЗЭМШИГЧ ТОГТООСОН ЖАГСААЛТ

| № | Байгууллагын нэр | Хөрөнгийн нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Бүртгэлд тусгах дүн | Шийдвэр | Байгууллага хүлээн авсан тухай | Хуучин эзэмшигч байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Анхны үнэ | Үлдэх өртөг | | | |
| 1 | Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар | Барилга | | | 96460000 | 79157666,78 | УИХ-ын 61-р тогтоол | Хүлээн авсан | Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар/үлдэх өртгийн дүнгээр шилжүүлсэн |
| | | Тээврийн хэрэгсэл | | | 87217560 | 11891913,03 | | | |
| | | Машин тоног төхөөрөмж | | | 72874003 | 22714094,73 | | | |
| | | Тавилга эд хогшил | | | 8046147 | 4574886,95 | | | |
| | | Ном | | | 122998 | 122998 | | | |
| | | Эргэлтийн хөрөнгө | | | | 80347000 | | | |
| | Нийт хөрөнгийн дүн | | | | 264720708 | 198808559,49 | | | |
| 1 | Баянхонгор сумын 5-р Цэцэрлэг | Төрийн банкны хуучин барилга | м2 | 292 | 278417 | 81297764 | УИХ-ын 61-р тогтоол | Хүлээн авсан | Төрийн банк |
| 2 | Баянговь сумын ЭМТ | Уаз-2206 пургон автомашин | ш | 1 | 26850000 | 26850000 | УИХ-ын 61-р тогтоол | Хүлээн авсан | Иргэний нисэхийн ерөнхий газар |
| 3 | Баянхонгор аймгийн Цагдаагийн газар | Хьюндай старекс маркийн 16-16БНА улсын дугаартай автомашин | ш | 1 | 16000000 | 16000000 | УИХ-ын 61-р тогтоол | Хүлээн авсан | Баянхонгор аймгийн Хөдөлмөрийн хэлтэс /хуучин нэрээр/ |
| | Дүн | | | | 307849125,00 | 322956323,49 | | | |

____________oOo____________